



**МОНГОЛ УЛС  
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**

**“ТУУЛЫН ХАР ТҮНЭ” –  
ТҮРГЭНИЙ ГОЛЫН БАЛГАС  
МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР  
2021**

Бүртгэлийн дугаар..... Нууцын зэрэглэл.....

Гэрээний дугаар.....

# **“ТУУЛЫН ХАР ТҮНЭ” – ТҮРГЭНИЙ ГОЛЫН БАЛГАС МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**Төслийн удирдагч:**

**Доктор /Ph.D/, дэд профессор  
Г.Эрэгзэн**

**Төслийн гүйцэтгэгчид:**

**Магистр Л.Мөнхбаяр  
Доктор /Ph.D/ Т.Батбаяр**

**Захиалагч байгууллага:**

**Нийслэлийн Соёл, Урлагийн газар**

**Тайлан өмчлөгч:**

**ШУА-ийн Археологийн хүрээлэн  
13343, Улаанбаатар, Жуковын гудамж-77  
ШУА-ийн нэгдсэн I байр**

**УЛААНБААТАР  
2021**

### **Судалгааны ажлын үндэслэл, зорилго:**

Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн Нийслэлийн Соёл урлагийн газартай хамтран “Туулын хар түнэ” орд, “Түргэний голын балгас”-ын малтлага судалгаа төсөлт ажлыг хэрэгжүүлж байна.

Монгол улсын нутагт VIII-XII зууны үеийн хот суурин, тэдгээртэй холбоотой булш бунхан, бичиг үсгийн дурсгал Монголын түүхийн бусад үетэй харьцуулбал олон байна.

Эдгээрийн нэг нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт орших “Түргэний голын Кидан балгас” буюу зарим судлаачдын үзэж буйгаар “Ван хааны орд-Туулын Хар түнэ орд” бөгөөд дундад зууны үеийн археологийн дурсгал юм. Уг дурсгалыг малтан судалснаар тус дурсгалын архитектурын онцлог, он цагийг нарийвчлан тогтоож, хотын ойролцоо хүн, малын үйлчлэл ихтэй газар буй газрыг харгалзан тус соёлын өвийн хүрээ хязгаарын хэмжээг тогтоон хамгаалах арга зүйг боловсруулах зэргээр тодруулан судлах боломжтой болох юм.

Мөн түүнчлэн Монголын нууц товчоонд дурдагдан буй Ван ханы суусан “Туулын хар түнэ” ордон эсвээс өмнөх судлаачдын бичсэнчлэн Хятан улсын үед хамаарах хэрэм эсэх талаар орчин үеийн шинжлэх ухааны арга зүйн дагуу малтлага судалгаа хийх энэхүү ойлголтын нэг мөр болгох, он цагийг тодотгох зэрэг асуудлууд тулгарч буй юм.

### **Судалгаа хийх газар:**

Улаанбаатар хотын нутаг Хан-Уул дүүрэг Түргэний голын балгас-“Туулын Хар Түнэ орд” хэмээх дурсгалт газар.

### **Судалгааны тойм**

Энэхүү балгасыг анх 1966 онд Х.Пэрлээ нарын судлаачид илрүүлэн олж илрүүлсэн бөгөөд 1979 онд гүймэг шинжин үзэж тус дурсгалаас олдсон олдворын зүйлсэд тулгуурлан “Түргэний голын кидан балгас” хэмээн бичсэн байдаг.

2005-2006 онуудад Их Монгол улсын 800 жилийн ойн хүрээнд МУИС-ын НШУС-ын Археологи-Антропологи тэнхим, Чингис хаан дээд сургууль хамтран археологич Д.Навааны удирдлагаар бага хэмжээний малтлага судалгаа явуулжээ. Тус шинжилгээний анги хэрмийн төв дунд хэсэгт орших голын байгууламжийг 400 ам дөрвөлжин талбайгаар цэвэрлэн ил гаргажээ. Өөрсдийн малтлагын материалд тулгуурлан мөн дурсгалын оршин буй байршил зэргийг харгалзан “Туулын хар түнэ орд Ван хааны ордны турь мөн хэмээн өөрсдийн бүтээлд бичжээ.

2009 онд судлаач У.Эрдэнэбат өөрийн бичсэн “Дундад зууны монгол оронд загалмайтны шашны урсгал нэвтэрч байсан товч түүхээс” хэмээх зохиолдоо уг дурсгалыг дахин авч үзэж олдвор хэрэглэгдэхүүнд тулгуурлан лавтайяа 8-р зууны дараа үеийн дурсгал хэмээгээд Х.Пэрлээгийн кидан улсын үед хамаарна гэх саналыг дэмжсэн байдаг.

## Судалгааны ангийн бүрэлдэхүүн

### Удирдагч

1. *Г.Эрэгзэн*. (Доктор (Ph.D), дэд профессор, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирал.

### Төслийн гүйцэтгэгчид:

1. *Л.Мөнхбаяр*. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр
2. *Т.Батбаяр*. ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)
3. *Б.Дашдорж*- ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан

### Туслах бүрэлдэхүүн:

1. Б.Мишээлт-МУИС оюутан
2. Э.Далайжаргал-МУИС оюутан
3. П.Сумъяабазар-МУИС оюутан
4. Ж.Ганди -МУИС оюутан
5. Ц.Пүрэвдорж-МУИС оюутан
6. Т.Ганцэцэг -МУИС оюутан
7. Ц.Цэцхүү -МУИС оюутан
8. М.Шинэтулга-МУИС оюутан
9. М.Болортуул -МУИС оюутан
10. Г.Тулга-эрдэнэ -МУИС оюутан

### Жолооч:

1. Б.Эрдэнэчимэг-HYUNDAI-Starex-0041 УАК
2. Н.Даваа-NISSAN Vanette-1739 УНЯ

### Тогооч:

1. Б.Алтансүвд

## **Дурсгалын байршил, тодорхойлолт**

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг хотоос баруун урагш 35 км орчим зайд Сонгинохайрхан уулын зүүн урд тал, Туул болон Түргэний гол нийлэх бэлчирээс дээд талд үерийн усны далангийн орчимд байрлана.

Дурсгалын агаарын зургийг авч, нарийвчилсан хэмжилт, тодорхойлолтыг хийж гүйцэтгэв. Хотын туурийн хэрэм болон түүний дотор орших төв барилга, жижиг барилга байгууламжуудын бүтэц, рельефийг харуулсан дэвсгэр зураг хийх ажлыг гүйцэтгэв.

Уг хэрэм голдоо нэг том түүний эргэн тойрон хэдэн жижиг туслах барилга байгууламжийн ор мөр мэдэгдэнэ.

Хэрэм ерөнхийдөө тэгш хэмтэй буюу хойноос урагш чиглэлтэй. Дөрвөн тал шороон хэрмийн хойд болон өмнөд талын хэсэг бага зэрэг намхан бөгөөд харин зүүн тал хамгийн өндөр сайн хадгалагдан үлджээ. Харин баруун талын хэсгийг үерийн далангийн барилгын ажлын үеэр хусан ашигласан бололтой бүр мөсөн алга болсон байдалтай байна.

Хэрэм одоо мэдэгдэж байгаагаар

-урд хана 253 м урт, дунджаар 14 м өргөн 0,5 м орчим өндөртэй, гадуур сувгийн хэмжээ 9 м өргөн,

-зүүн хана 273 м урт, дунджаар 16 м өргөн, 1,5 м орчим өндөртэй, гадуур сувгийн хэмжээ 7-9 м өргөн, гүн 0,7 м, хэрмийн дунд хэсэгт хаалганы ором бололтой намхан хэсэг –хэмжээ 8,2 м орчим байна

-хойд хана 152 м урт, дунджаар 13 м өргөн, 0,5 м орчим өндөртэй, гадуур сувгийн хэмжээ 8 м өргөн байлаа.

-баруун хана бүрэн устсан буюу эвдэгдсэн мэдэгдэх зүйл үгүй

### **1. МАЛТЛАГА СУДАЛГАА**

Хотын хэрэмний хэсэгт бүтэц, он цагийг тодорхойлох зорилгоор хэрмийн хана, суваг, дотор хэсгийн хамруулан 2 x 26 м сувгийн малтлага гүйцэтгэв.

Тус зүсэлтийн явцад овгор хэрмийн гадна талд буюу сувгийн урд хэсэгт уг сувгийг малтах явцад гарсан шороог овоолсон байна. Улмаар хэрмээс шууд үргэлжилсэн суваг гарсан бөгөөд сувгийн хэмжээ 4 м бөгөөд одоогоор мэдэгдэж буйгаар 1-1,5 м гүнтэй суваг байсан нь тодорхой болов. Уг сувгийг ус нэвчихээс сэргийлэн 4 см орчим өргөнтэй улаан өнгийн шавраар нямбайлан доторлосон нь хэрмийн гадуур ус зайлуулах суваг зориуд хийсэн инженерийн байгууламж болохыг илтгэж байна. Мөн уг сувгийн дээр элсэн үе хучин тогтсон бөгөөд энэ нь тухайн цагт сувгийг ашиглахаа больж эхэлсэн үеэс тогтсон болов уу.

Мөн одоогийн мэдэгдэж буйгаар 4 м өргөн, 70 см өндөр шаргал шаврыг 13 үе болгон үелэн тагтаршуулсан шороон хэрэмтэй байв. Уг хэрмийн дээд хэсэгт болон хоёр талаар нь мал амьтаны яс, барилгын материалын үлдэл хэсгүүд ихээхэн хэмжээтэй илрэв. Малтлагын явцад хэрмийн хөрс бор шаргал бөгөөд тухайлсан дагтаршуулсан хэрмийн хөрснөөс бусад газар элсэрхэг шар хөрстэй байлаа.

Хэрмийн дотор талд мал, амьтны ясны хаягдал бүхий “хаягдалын нүх” 1x1 хэмжээтэй илэрсэн нь тухайн хэрмэнд оршин суугчдын үлдэл бололтой. Тус хаягдалын нүхэнд ихээхэн хэмжээний бог, бод малын яс, үнс, ваар савны хагархай илэрсэн бөгөөд хэрэм нурах явцад уг нүхийг тагласан маягтай даржээ. Тус нүхний орчмоос болон нүхэн дотроос “хятаны үеийн хээ” гэж тогтоогдсон дусал хээтэй вааран савны үлдэгдэл илэрсэн нь тус хэрмийг Хятан улсын үед холбогдож болохыг харьцуулсан он цагийн хүрээнд оршиж байсныг илтгэж байна. Улмаар байгалийн шинжлэлийн аргаар лабораторийн нарийвчилсан шинжилгээ хийх явцад хэрмийн он цагийг улам баттай тогтоож болохуйц дээж, эх хэрэглэгдэхүүнийг дээж болгон авлаа.

## 2. МАЛТЛАГА СУДАЛГАА

Хэрмийн төв хэсэгт буй байгууламж буюу судлаачдын “Хар түнэ орд” гэх барилга ерөнхий хэрмийн хэмээс өөр буюу зүүн урагш чиглэлтэй бөгөөд азимутын 170 градусыг чиглэжээ.

Уг байгууламж одоогийн өндөр 2,0-2,5 м бөгөөд тэгш өнцөгт дөрвөлжин, тэгш зассан суурьтай байна. Хэмжээ 34x18,5 м урд хэсэгтээ уруудсан налуу үүдний зохион байгуулалтаас бүрдэнэ.

Тус барилгын байгууламж тус бүрээр авч үзвэл өмнөд талаас өгссөн налуу байгууламж, 1-р байгууламж үүдний хэсэгт хамаарах бөгөөд одоогийн хэлбэр нь “П” хэлбэрийг үүсгэсэн өрлөг бүхий юм. Өрлөгийн 2 талаар байгалийн хавтгай чулууг хөвөөлөн суулгасан байдалтай. Тоосгоны хувьд 30 см урт, 12 см өргөн, 6 см зузаантай байв.

2-р байгууламж тэгш өнцөгт хэлбэртэй байх бөгөөд голын хэсгээрээ тоосго ихэд бутарсан буюу хөл хөдөлгөөн ихтэй байсныг илтгэнэ. Тоосгоны хэмжээ том 34 см урт, өргөн 16 см, зузаан 6 см байна.

3-р байгууламж “гол танхим” нийт талбайг тэг дөрвөлжин тоосгоор шалласан бололтой гэвч шалны баруун хэсгийн тоосго нийтдээ үрэгдсэн зөвхөн зүүн талын хэсэгт үлдэн хоцорчээ. Шалны тоосгоны хэмжээ 28x28 см. Танхимын баруун зүүн талд тусгай “жигүүр”-тэй бөгөөд танхим, жигүүр 2-г зах хэсгээр нь хавиргалан босгосон 2 давхар тоосгон хэсэг тусгаарлана. Гол танхимын дунд хэсэгт баруун урдаас зүүн хойш чиглэсэн 4 эгнээ тоосгон шал тусгайлан гаргасан бөгөөд одоогоор зориулалт тодорхойгүй байна.

Мөн гол танхимийн шалны дээр хавиргалан өрсөн 1м x 2м зүүнээс баруун тийш чиглэсэн тавцан хэлбэрийн өрлөг байв. Танхимын зүүн хойд хэсэгт 1 м диаметр бүхий сүүлийн үеийн эвдэн сүйтгэлийн ул мөр болох нүх байх бөгөөд шалыг цөмлөн доош ухсан хэмжээ 120 см байв.

Тус танхимийн баруун болон зүүн урд булангаас (үүдний танхимын 2 талаар гадагш чиглэсэн) баруун урагш болон зүүн урагш уруудуулан чиглэсэн тоосгоор хийсэн сувагтай бөгөөд зүүн урд-2.4 м урт, 24 см өргөн, сувгийн дотор хэсэг 12 см, гүн 6 см, баруун урд-3,30 урт 22 см өргөн, сувгийн дотор хэсэг 12 см, гүн 6 см байна.

4-р байгууламж “хойд танхим” 2 талаараа байгалийн хавтгай чулуугаар шалласан зах хэсэгт нь 2 эгнээ тоосгыг завсар гарган ханалан өрсөн бөгөөд энэ нь “хойд танхим”-ыг бүрэн хүрээлсэн байна. Зүүн талд “орц хаалга” гэмээр эс бол хэсэг тоосгон хана 160 см газар үрэгдэн алга болжээ. Хавтгай чулуугаар шалласан гэж үзвэл зах хөвөөг нь улаан тоосгоор ханалан хязгаарлажээ. Хавтгай

чулуугаар шалласан хэсэгтэй шууд залгаа түүхий тоосго болон дутуу шатаасан улбар шар тоосгон хана цэвэрлэгээний явцад энэхүү танхимын баруун хэсэгт илрэв. Уг хананы урд үзүүрт дөрвөлжин суурьтай дугуй хэлбэртэй баганын суурь, дунд хэсэгт дөрвөлжин хэлбэртэй баганын суурь илрэв. (Эртийн Түрэгийн тахилын онгоны хавтанг ашигласан байдалтай байсан нь түүний дээр байх хээ угалзын байдлаар мэдэгдэнэ).

2006 оны малтлагын хүрээг дагуулан сэргээн цэвэрлэх явцад “хойд танхим”-ийн урд хэсгээр чулуун шигтэгмэл шалны чимэглэл илрэн олдсон бөгөөд зүүнээс баруун тийш чиглэсэн байлаа. Уг чимэглэлийн дээр зүүнээс баруун чиглэсэн 2 үе тоосгон өрлөг байгаа нь чимэглэл өмнөх үед байсныг илтгэнэ. Ерөнхий хэмжээ 80-90 см талаар нь 10-12 см өргөн 20 см урттай тоосгоор жаазлан хийсэн 15 өөр дүрслэл гарган урлажээ. Зарим хэсэг нь өмнөх малтлагын үндсэн талбайд орж эвдэгдсэн бөгөөд мөн хоёр эгнээ чимэглэлтэй байсан нь мэдэгдэнэ.

#### **Чулуу шигтэгмэл чимэглэл.**

**Жаазалсан тоосгоны хэмжээ 12 см өргөн, 24 см өргөн. Зүүн урдаас эхлэн сөөлжлүүлэн дугаарлав.**

- 1- Дүрслэл: 100 см жаазалсан талбайд амьтаны биеийг дүрсэлсэн. Одоогийн мэдэгдэж буй өргөний хэмжээ 40 см.
- 2- Дүрслэл: 94 см жаазалсан талбайд ургамалын дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 50 см байна.
- 3- Дүрслэл: 95 см жаазалсан талбайд ургамал цэцгийн дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 44-48 см байна.
- 4- Дүрслэл: 94 см жаазалсан талбайд ургамал цэцгийн дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 50 см байна.
- 5- Дүрслэл: 87 см жаазалсан талбайд ургамал цэцгийн дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 44-66 см байна.
- 6- Дүрслэл: 84 см жаазалсан талбайд эмбүү модонд ургаж буй дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 60 см байна.
- 7- Дүрслэл: 84 см жаазалсан талбайд дөрвөн дэлбээт ургамал цэцгийн дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 60 см байна.
- 8- Дүрслэл: 78 см жаазалсан талбайд ургамал, модны дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 50 см байна.
- 9- Дүрслэл: 88 см жаазалсан талбайд дүрслэл устан эвдэрсэн. Одоогийн мэдэгдэж буй өргөн 54 см байна.
- 10- Дүрслэл: 95 см жаазалсан талбайд дүрслэл устан эвдэрсэн. Одоогийн мэдэгдэж буй өргөн 44-48 см байна.
- 11- Дүрслэл: 75 см жаазалсан талбайд хилэнцэт хорхой дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 40 см байна.
- 12- Дүрслэл: 60 см жаазалсан талбайд гурван дэлбээт цэцгийн дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 44 см байна.
- 13- Дүрслэл: 76 см жаазалсан талбайд дүрслэл утсан эвдэрсэн. Одоогийн мэдэгдэж буй өргөн 35-40 см байна.
- 14- Дүрслэл: 76 см жаазалсан талбайд эрвээхий эсвэл сарьсан багваахай дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 34-45 см байна.
- 15- Дүрслэл: 55 см жаазалсан талбайд ургамал цэцгийн дүрслэлтэй. Одоогийн мэдэгдэж буй өргөн 46 см байна.

## 2.1 Малтлагын тодорхойлолт

**Талбай ВВ25.** Тус барилгын дээд тавцанг 2006 онд анх малтсан байдаг бөгөөд 2м орчим өндөр суурин дээр барьсан барилгын тоосгон шалыг ил гарган орхижээ. Тухайн үед малталгүй орхисон жижиг талбай нь барилгын хоймор хэсэг бөгөөд тэнд нь хажуудаа чулуун овоотой тугийн шон байна.

Энд тус барилгын хамгийн өндөр цэг орших бөгөөд h-55 см өндөртэй байна. Энэ нь бидний өгсөн зохиомол үе давхрагын 1-р үед хамаарах юм.

Дээрх тугын шонг дайруулан байгууламжийн уртрагын дагуу барилгын төв тэнхлэг гэж үзэн түүний зүүн хойд талд 10 х 10 м хэмжээтэй талбай үүсгэн түүнийг нийт дурсгалт газрын талбайг өрөгт хуваасан системийн дагуу ВВ25 хэмээн нэрлэв.

Улмаар тус талбайг мөн дотор нь 1м<sup>2</sup> бүрийг 1-100 хүртэл дугаар өгч хуваасан. ВВ25-ын баруун талд 10 х 2 м хэмжээтэй талбайд малтлагыг эхлүүлсэн бөгөөд энэ нь 01-91, 02-92 -р өрөг, PL-5-12 хүртэл хазайлттай налууд нийт 20 квадрат багтана.

Малтлагын талбайн өмнө тал буюу 91,92, 81, 82 - р талбайг малталгүй орхисон бөгөөд энэ хэсэг нь хойд барилгын дотор талд орох юм. Малтлагын эхний үед 31,41-р өргөөс тоосгоны хагархай гарч эхэлсэн. 21-р өргөөс хавтгай чулуун тоосгоны хагархай болон малын яс гарч байна.

Барилгын тавцан хэсэгт буюу 71, 72, 61, 62-р өрөгт эхний 20 см гүнд тавцангийн чулуун шал илэрсэн. Энэ нь 4-р үе бөгөөд малтлагаас дээврийн ваарны хагархай хэсгүүд болон зээ бадан дүрстэй нүүр ваар илэрч байлаа. Өрөг 71, 72 – оос барилгын хойд ханын тоосгон өрлөгийн хэсэг илэрсэн ба малтлагын талбайн өмнө ханаас 20 см хэртэй тал хэсэг нь цухуйн гарлаа.

Илэрсэн ханын өндөр 15 см бөгөөд нийт 7 ш тоосго мэдэгдэх бөгөөд доош 2 үе өрсөн байна. тоосгоны дундаж хэмжээ 30x15x4.5 байна. Өрлөгийн өндөр h-102 буюу 4-р үед хамаарна. Гадна талын чулуун хавтан h-118 бөгөөд энэ нь PL-5 болох юм.

31, 32-р өргөөс тавцангийн хойд хана илэрч байна. Малтлагын гүн 83 см 11-р үе буюу h-244 байна. ханын гадна талаар барилгын нуранги (дээврийн ваар, тоосго, хавтгай чулуу) олноор илэрсэн. Мөн энэ үед 21, 22 – р өрөгт урт хавтгай чулууг босгож хийсэн хашлага чулууд илэрсэн нь дэлдсэн суурийн хашлага бололтой. Үүний дээр болон дотор хэсэгт барилгын нуранги 68 см зузаантай бөгөөд мөн үүний дотор талд 50 см зузаантай барилгын хоггүй шаварлаг зөөлөн хөрс байна. 11, 12 – р өргөөс PL-14 дээр тоосгоны нуранги дуусаж дээврийн ваарын нуранги гарч, 1,2-р өрөгт барилгын нуранги дуусаж малтлагыг зогсоов.

**Талбай ВВ35.** Уг талбай нь өмнөх талбайн зүүн тал бөгөөд үүнийхээ баруун талд 4 х 10 м хэмжээтэй талбай нээв. Энэ нь барилгын суурийн зүүн хойд булангын хэсэг бөгөөд өрөгийн дугаар нь 21-24, 31-34, 41-44, 51-54, 61-64, 71-74, 81-84, 91-94 болно.

Эхний ээлжинд эдгээрийн 91, 92 – 51, 52 – р өргийг доош 56 – 77 см орчим гүнтэй малтаж PL- 10 түвшинд хүрсэн нь үе 9 болох юм. 41, 42 – р өрөгт дээрхээс 1 үе доош малтжээ. 93, 94 – 63, 64 – р өргийг нэг төвшинд хүргэсэн бөгөөд PL – 13-д хүргэн малтлаа.



Малтлагын эхний үед 2006 оны малтлагын шороо байсан бөгөөд жижиг барилгын хог бүхий зөөлөн шороо юм.

Энэ нь хамгийн зузаан хэсэгтээ 57 см орчим байх ба газрынхаа уруу нимгэрч байна. Сул шорооноос доош барилгын нуранги эхлэх бөгөөд нурангийн дотор хэсэгт 50 см орчим өргөнтэй сулавтар шороо гарч байна. Уг талбайн малтлагын гүн доод хэсэгтээ 60 см, дээд хэсэгтээ 128 см гүнтэй малтжээ. Талбайн 53, 54 – 23, 24, 21, 22, 31, 32 – р өргүүдэд PL – 14-т хүргэн малтсан бөгөөд барилгын нуранган үе дууссан байна. 31 – р өрөгт өргийн өмнөд ханаас 14 см зайд дэлдэж дагтаршуулсан барилгын суурь илэрсэн ба түүний ёроол хэсгээс хөндлөн шургааг мод илэрлээ. Гүн h-284 ба энэ газрын өнгөн хөрснөөс доош 72 см бөгөөд 13 үед модны голч 10 см байна.

Дагтаршуулсан ханаас 50 см өргөнтэй өмнөхтэй ижил барилгын хоггүй сийрэг шаварлаг хөрс илэрч байлаа. Малтлагын талбайн баруун хойд булан хэсэгт буюу 21 – р өргийн баруун хойд хэсэгт 50 см гүн, 94- р өргийн зүүн хойд буланд 23 см гүнтэй малтлаа. PL – 14 байна. Энэ хэсэгт барилгын нуранги дундаас барилгын чимэглэлийн зориулалттай элдэв төрлийн хээ болон амьтаны дүрс бүхий нимгэн шавар тоосго илэрч байв.

Мөн 13-р үеэс эхлэн товгор хээтэй тосгуур ваарууд гарч байна. дагтаршуулсан хананы доод хэсгээс чулуу болон тоосгоны хэлтэрхий илэрч байгаа нь дүүргэлтийн шороо байсан бололтой.

**Талбай ВВ36.** Уг талбай нь ВВ35 талбайн өмнө талд 10x10 хэмжээтэй юм. Барилгын зүүн ханын нурангын налуу хэсэг юм. Малтлагыг ВВ36 талбайн урд хэсэгт 10x2 хэмжээтэй эхлүүллээ. Өргийн дугаар нь 81-90, 91-100 байна.

Малтлагын эхний үед 81-85, 91-95 өрөгт 2006 оны малтлагын шороо илэрсэн бөгөөд хамгийн зузаан хэсэг нь 82,92 өрөг дээр 87 см зузаантай байлаа. 81,91 өрөгт доош 2 үе малтахад 50 см гүнээс барилгын суурийн дагтаршуулсан хатуу хөрс гарлаа.

83,93-р өрөгт 60 см гүнээс барилгын нурангын бөөгөнрсөн хэсэг гарч эхлэв. Энэ нь 18 см зузаантай үргэлжилнэ. Эндээс дээврийн ваарны нуранги ихээр гарч байна. Эдгээр өргийг PL – 13 хүртэл малтсан. Энэ нь 12-р үе бөгөөд эндээс барилгын суурийн хашлага мод илэрсэн. Гүн нь өнгөн хөрснөөс 153 см гүнд байна. Хашлага модны голч 12 см уг модны доор мөн адил хэмжээтэй өөр нэг мод давхарлаж тавьсан нь мэдэгдэж байна. Хашлага модноос 56 см зайнд мөн нэгэн хөндлөн модны үлдэгдэл илэрсэн нь барилгын нуранги бололтой.

Барилгын суурийн хана, барилгын нуранги хоёрын хооронд 55 см зайтай. Ханын зүсэлтээс үзэхэд барилгын нурангины зузаан 65 см байна. Түүнээс доош 30 см гүнд шаргал өнгийн барилгын нурангийн шороо 223 см урттай үргэлжлэнэ. Зузаан нь дээд хэсэгтээ 35см байна. 95,85-р өргийн малтлагаас барилгын нурангид чулуу холилдож эхэлсэн нь ажиглагдаж байсан. малтлагын талбайн зүүн хойд булангийн 90-р өрөгт PL – 16-аас доош 1м гүн сорилын малтлага хийж үзэхэд 15-р үеэс байгалийн хөрсөн давхарга илэрч байна. Ингэснээр уг малтлагын ажлыг дуусгаж булав.

## ХАВСРАЛТ ЗУРАГ



Зураг 1. Түргэний голын балгас-Хар түнэ ордны зураглал



Зураг 2. Түргэний голын балгас-Хар түнэ ордны өндөршилийн зураглал



Зураг 3. Голын байгууламжийн малтахаас өмнөх зураглал



Зураг 4. Голын байгууламжийн цэвэрлэгээний дараах зураглал



Зураг 5. Голын байгууламжийн цэвэрлэгээний дараах зураглал



Зураг 5. Голын байгууламжийн цэвэрлэгээний дараах зураглал

Шалны хэсэг



Зураг 6. Голын байгууламжийн цэвэрлэгээний дараах зураглал

Ус зайлуулах суваг баруун тал



Зураг 7. Голын байгууламжийн цэвэрлэгээний дараах зураглал

Ус зайлуулах суваг зүүн тал



Зураг 8. Голын байгууламжийн цэвэрлэгээний дараах зураглал

Байгууламжийн гадуурхи дэвсмэл шал



Зураг 9. Голын байгууламжийн цэвэрлэгээний дараах зураглал

Байгууламжийн гадуурхи дэвсмэл шал



Зураг 10. Хэрмийн зүсэлт дагтагшуулсан хэрэм



Зураг 11. Хэрмийн зүсэлт сувгийн харагдах байдал





Зураг 12. Хэрмийн зүсэлт сувгийн ёроолын дагтагшуулсан шал



Зураг 13. Хэрмийн зүсэлт сувгийн ёроолын дагтагшуулсан шал



Зураг 14. Хэрмийн зүсэлт хэрмийн дотор хэсэгт орших хаягдалын нүх



Зураг 15. Хэрмийн зүсэлт хэрмийн дотор хэсэгт орших хаягдалын нүх хэрэм нурахад дарагдсан байдал



Зураг 16. Гол барилгын хойд хэсгийн зүсэлт, дагтаршуулсан тавцан болон хүчитгэн хийсэн чулуун хашлага



Зураг 17. Гол барилгын хойд хэсгийн зүсэлт, дагтаршуулсан тавцан болон хүчитгэн хийсэн чулуун хашлага



Зураг 18. Гол барилгын зүүн хэсгийн зүсэлт, дагтаршуулсан тавцан



Зураг 19. Гол барилгын зүүн хэсгийн зүсэлт, дагтаршуулсан тавцан



Зураг 20. Гол барилгын зүүн хойд хэсгийн зүсэлт, дагтаршуулсан тавцан



Зураг 21. Гол барилгын зүүн, зүүн хойд, хойд хэсгийн зүсэлт-дагтаршуулсан тавцан



Зураг 22. Гол барилгын чулуун дэвсмэл шалны харагдах байдал



Зураг 23. Гол барилгын чулуун дэвсмэл шалны харагдах байдал



Зураг 24. Гол барилгын чулуун дэвсгэл шалны харагдах байдал



Зураг 25. Гол барилгын чулуун дэвсгэл шалны харагдах байдал



Зураг 26. Гол барилгын олдвор барилгын чимэглэл



Зураг 27. Гол барилгын олдвор барилгын чимэглэл





Зураг 28. Гол барилгын олдвор барилгын чимэглэл



Зураг 29. Гол барилгын олдвор барилгын чимэглэл



Зураг 30. Судалгааны ангийн бүрэлдэхүүн ажлын явц



Зураг 31. Судалгааны ангийн бүрэлдэхүүн хэрмийн зүсэлтийн явц



Зураг 32. Судалгааны ангийн бүрэлдэхүүн хэрмийн зүсэлтийн явц



Зураг 33. Судалгааны ангийн бүрэлдэхүүн хэрмийн зүсэлтийн явц



Зураг 34. Судалгааны ангийн бүрэлдэхүүн голын байгууламжийн зүсэлтийн явц



Зураг 35. Судалгааны ангийн бүрэлдэхүүн голын байгууламжийн зүсэлтийн явц



Зураг 36. Судалгааны ангийн бүрэлдэхүүн баримтжуулалт



Зураг 37. Хэрмийн зүсэлтийг нөхөн сэргээсэн байдал



Зураг 38. Голын байгууламжийг хамгаалсан байдал



Зураг 39. Голын байгууламжийг нөхөн сэргээсэн байдал

## Дүгнэлт

1. Дурсгалын агаарын зургийг авч, нарийвчилсан хэмжилт, тодорхойлолтыг хийж гүйцэтгэв. Хотын туурийн хэрэм болон түүний дотор орших төв барилга, жижиг барилга байгууламжуудын бүтэц, рельефийг харуулсан дэвсгэр зураг хийх ажлыг гүйцэтгэв.

2. Хотын хэрэмний хэсэгт бүтэц, он цагийг тодорхойлох зорилгоор 2 х 26 м сувгийн малтлага гүйцэтгэж, 4 м өргөн, 70 см өндөр шавар үелэн тагтаршуулсан шороон хэрэм, түүний гадна талаар 4 м өргөн, 60 см гүн сувагтай байгааг тогтоов. Уг сувгийг ус нэвчихээс сэргийлэн улаан өнгийн шавраар нямбайлан доторлосон нь хэрмийн гадуур ус зайлуулах суваг зориуд хийсэн инженерийн байгууламж болохыг илтгэж байна. Хэрмийн дотор талд мал, амьтны ясны хаягдал бүхий нүх илэрсэн нь лабораторийн нарийвчилсан шинжилгээ хийх, хэрмийн он цагийг баттай тогтоох чухал хэрэглэгдэхүүн болж байна. Хэрмийн он цагийн хувьд харьцуулсан аргаар он цагийг тоймлон үзвэл Хятаны үеийн хэрэм болох нь тогтоогдож буй бөгөөд энэ нь нийслэл орчмын бүс нутагт лавтайяа 1100-1000 жилийн өмнөөс хот суурин барьж суурьшин сууж байсныг батлан харуулах томоохон суурьшлын ул мөр болох юм.

3. Хэрмийн дотор орших төв ордны дээд хэсгийг бүрэн цэвэрлэж, дэвсгэр зургийг үйлдэж, суурийн хэсэгт зүсэлт явуулж бүтэц зохион байгуулалтыг тодорхойлов. Уг ордны туурь нь шороон хэрэмний ерөнхий тэг, чиглэлтэй давхцахгүй байгаа нь өөр цаг үед холбогдохыг шууд илэрхийлж байна. Ордныг байгуулсан шороон суурь нь 34 х 18.5 м хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэй бөгөөд цайвар өнгийн шавар дагтаршуулан дэлдэж 2,0-2.5 м өндөр шороон давцан үүсгэн, шатаасан тоосгоор нямбайлан шалласан болохыг тодорхойлов.

Шалны тоосгон өрлөгөөс үзэхэд уг барилга нь үүдний угтах хэсэг болон хэд хэдэн томоохон тасалгаанаас бүрдэх бөгөөд барилгын материал болох дээврийн ваар, нүүр ваар, тоосго, барилгын гоёл чимэглэл багагүй илэрч байгаа нь нарийн мэргэжлийн урчуудын оролцоотой, инженерийн хэмжилт тооцоо, төлөвлөлтийн дагуу баригдсан архитекторын уран тансаг шийдэлтэй, гоёмсог хийцтэй ордон байсныг илэрхийлж байна.

Малтлагын явцад ордны шалыг тоосгоор шахаж хийснээс гадна хээ чимэглэл бүхий шигтгэмэл (мозаика) шалны арга зүйгээр үйлдсэн болохыг анх удаа илрүүлсэн нь эрдэм шинжилгээний хувьд ховор тохиолдох баримт хэрэглэгдэхүүн болж байна. Ордны суурийн зүсэлтийн малтлагаар он цаг тогтоох модон байгууламжны үлдэгдэл илэрч олдоод байна.

4. Малтлага судалгаанд үндэслэн ордныг тухайн үеийн байдлаар нь сэргээн зурах ажлыг эхлүүлээд байна.

5. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх ажлын хэсгийн хүрээнд уг дурсгалын хамгаалалтын бүсийг тогтоосон бөгөөд дурсгалын хадгалалт хамгаалалт, ил үзмэр, мэдээллийн төв, үйлчилгээний хэсгийг харуулсан төлөвлөлт бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох урьдчилсан эскиз зураг гаргах ажлыг гүйцэтгэж байна.

ХАВСРАЛТ 2

№ 1-6

СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ:

СОЁЛЫН САЙДЫН 2021 ОНЫ 04 ДУГААР  
САРЫН 09-НЫ ӨДРИЙН 12 ДУГААР ТУШААЛААР

Г. Фрагдон, Л. Мунхбаяр

УДИРДАГЧТАЙ  
"Түүхийн Хар Түмэ өргөн  
малбалаа судалгаа" тасал

АНГИД ПАЛЕОНТОЛОГИ, АРХЕОЛОГИЙН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАЙГУУЛ, МАЛТЛАГА  
СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОВ.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:  
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Гарын үсэг (тэмдэг) нэрийн тайлал

9028090413 СТС2233 6594204

Засаг захиргааны нэгжийн нэр:  
Улаанбаатар хот  
Сонинхохайрхан дүүрэг

Газар нутгийн нэр:  
Тургэтийн голын хороо

Дурсгалын нэр:  
Хот сургууль

Солбицол:

Хугацаа:  
20 21 оны 06 дугаар сарын 15-ны өдөр  
20 21 оны 07 дугаар сарын 15-ны өдөр

Энэхүү зөвшөөрөл нь зөвхөн зөвшөөрөлд  
бичигдсэн газар, хугацаанд хүчинтэй.



БАТЛАВ:



Г.ЭРЭГЗЭН /ШУА-ИЙН АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ, ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР/

**“ТУУЛЫН ХАР ТҮНЭ” ОРДЫН МАЛТЛАГА СУДАЛГАА ТӨСӨЛТ АЖЛЫН 2021  
ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН УДИРДАМЖ**

Улаанбаатар хот

2021 оны 07-р сарын 05.

**Судалгааны ажлын үндэслэл, зорилго:**

Тус хүрээлэн Нийслэлийн Соёл урлагийн газартай хамтран “Туулын хар түнэ” ордын малтлага судалгаа төсөлт ажлыг хэрэгжүүлж байна.

Монгол улсын нутагт VIII-XII зууны үеийн хот суурин, тэдгээртэй холбоотой булш бунхан, бичиг үсгийн дурсгал Монголын түүхийн бусад үетэй харьцуулбал олон байна.

Эдгээрийн нэг нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт орших “Түргэний голын Кидан балгас” буюу зарим судлаачдын үзэж буйгаар “Ван хааны орд-Туулын Хар түнэ орд” бөгөөд дундад зууны үеийн археологийн дурсгал юм. Уг дурсгалыг малтан судалснаар тус дурсгалын архитектурын онцлог, он цагийг нарийвчлан тогтоож, хотын ойролцоо хүн, малын үйлчлэл ихтэй газар буй газрыг харгалзан тус соёлын өвийн хүрээ хязгаарын хэмжээг тогтоон хамгаалах арга зүйг боловсруулах зэргээр тодруулан судлах боломжтой болох юм.

Мөн түүнчлэн Монголын нууц товчоонд дурдагдан буй Ван ханы суусан “Туулын хар түнэ” ордон эсвээс өмнөх судлаачдын бичсэнчлэн Хятан улсын үед хамаарах хэрэм эсэх талаар орчин үеийн шинжлэх ухааны арга зүйн дагуу малтлага судалгаа хийх энэхүү ойлголтын нэг мөр болгох, он цагийг тодотгох зэрэг асуудлууд тулгарч буй юм.

**Судалгаа хийх газар:**

Улаанбаатар хотын нутаг Түргэний голын балгас хэмээх дурсгалт газар.

**Судлагдсан байдал:**

Энэхүү балгасыг анх 1966 онд Х.Пэрлээ нарын судлаачид илрүүлэн олж илрүүлсэн бөгөөд 1979 онд гүймэг шинжин үзэж тус дурсгалаас олдсон олдворын зүйлсэд тулгуурлан “Түргэний голын кидан балгас” хэмээн бичсэн байдаг.

2005-2005 онуудад МУИС-ын НШУС-ын Археологи-Антропологийн тэнхим, Чингис хаан дээд сургууль хамтран археологич Д.Навааны удирдлагаар бага хэмжээний малтлага судалгаа явуулжээ. Тус шинжилгээний анги хэрмийн төв дунд хэсэгт орших голын байгууламжийг 400 ам дөрвөлжин талбайгаар цэвэрлэн ил гаргажээ. Өөрсдийн малтлагын материалд тулгуурлан мөн дурсгалын оршин буй байршил зэргийг харгалзан “Туулын хар түнэ орд Ван хааны ордны турь мөн хэмээн өөрсдийн бүтээлд бичжээ.

2009 онд судлаач У.Эрдэнэбат өөрийн бичсэн “Дундад зууны монгол оронд загалмайтны шашны урсгал нэвтэрч байсан товч түүхээс” хэмээх зохиолдоо уг дурсгалыг дахин авч үзэж олдвор хэрэглэгдэхүүнд тулгуурлан лавтайяа 8-р зууны дараа үеийн дурсгал хэмээгээд Х.Пэрлээгийн кидан улсын үед хамаарна гэх саналыг дэмжсэн байдаг.

**Судалгааны арга:**

Археологийн хээрийн шинжилгээний малтлага судалгааны арга зүйг ашиглана.

**Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүн:**

1. Л.Мөнхбаяр (*ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан*)
2. Т.Батбаяр (*ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор*)
3. Б.Дашдорж (*ШУА-ийн Археологийн хүрээлэн ажилтан*)
4. Туслах ажилтан – 10, жолооч – 2, тогооч – 1.

**Санхүүжилт:**

- Нийслэлийн Соёл, урлагийн газар

**Багаж тоног төхөөрөмж:**

- Гэр, майхан, гал тогооны хэрэгсэл, цахилгаан үүсгүүр
- Малтлагын багаж хэрэгсэл

**Хугацаа:** 2021 оны 07-р сарын 09-наас 08-р сарын 08 хүртэл

**Унаа хөсөг:** Хүн тээврийн зориулалтын машин-2.

**Судалгааны урьдчилсан үр дүн:**

Археологийн малтлага судалгааны ажлын материалыг боловсруулан эрдэм шинжилгээний тайлан бичих, судалгааны ажлын урьдчилсан үр дүнгийн талаар мэдээлэх болно.

Удирдамж боловсруулсан:



Л.Мөнхбаяр

